

**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Д.Хаянхярваа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийг Төсвийн байнгын хороо 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ ирүүлсэн бөгөөд зарчмын зөрүүтэй санал гаргаагүй байна.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2015 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах горимын санал гаргаж, хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэйгээр дэмжлээ.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг ердийн журмаар тогтоох нь зүйтэй гэж үзэв.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН
НЭРИЙН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд доор дурдсан агуулга бүхий 13¹ дүгээр зүйлийг нэмсүгэй:

“13¹ дүгээр зүйл. Өндөр насын тэтгэвэр тогтоолгоход сонголт хийх эрх

13¹.1. Энэ хуулийн 7.1-д заасан болзлыг хангасан даатгуулагч өндөр насын тэтгэвэр тогтоолгоход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд, эсхүл энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан нөхцөлөөс сонголт хийж болно.”

Гарын үсэг